



## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/62

Сүхбаатар сум

### Мал, амьтны халдварт өвчингүй, тайван байдлыг хадгалах тухай

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3- "а", "Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4-6.6, 14 дүгээр зүйлийн 14.5-14.7 дахь заалт, 23 дугаар зүйлийн 23.1, 23.5 дахь заалтууд, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А/40 тоот тушаал, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны А/256 тоот тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2009 оны 20 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ аймгийн үхэр сүргийг "Үхрийн сүрьеэ, үхрийн лейкоз өвчингүй, тайван байдал"-ыг тогтоон Монгол Улсын хэмжээнд зарлаж, батламж олгосон мал, амьтны гоц халдварт өвчний вакцин хэрэглэдэггүй эрүүл бүсийн статусаа хадгалж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, Монгол Улсын Засгийн газраас тус аймгийг "Эрчимжсэн МАА-газар тариалангийн бүс нутаг" болгон зарласантай холбогдуулан малын механик өсөлтийг бууруулах зорилгоор бусад аймаг, сумаас тус аймаг руу чиглэсэн амьд малын шилжилт хөдөлгөөнийг бүрэн хязгаарласугай.


2.Амьд мал, амьтан нэвтрүүлэх зайлшгүй шаардлага (экспорт, импорт) үүссэн нөхцөлд аймаг, сум хоорондын мал эмнэлгийн хяналтын түр цэгээр Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйл заалтын шаардлагыг бүрэн хангуулж, нэвтрэх бүх малд толгой дараалан гоц халдварт өвчингүй эрүүл болохыг нотолсон магадлан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн шийдвэрлэхийг Мал эмнэлгийн газрын дарга /С.Ариунтөгс/-д даалгасугай.

3.Үхрийн сүрьеэ, лейкоз өвчний тандалт шинжилгээнд суурин, хагас суурин эрчимжсэн аж ахуйн үхэр сүргийг өөрсдийнх нь зардлаар бүрэн хамруулж, үнэлгээ үр дүнг тооцсугай.

4.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж хариуцлагагүй хандсан хүн, хуулийн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх, хууль тогтоомжийн дагуу хяналт

тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Ж.Отгонхүү/, Мал эмнэлгийн газрын дарга /С.Ариунтөгс/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ